


Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 135 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт.

“ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨААТҮГ-ЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



1.1. “Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (цаашид энэ дүрэмд “Парк” гэх) нь орон нутгийн хэмжээнд хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох судалгаа, бодлогын бичиг баримт боловсруулах ажилд хамтран оролцох, зөвлөх, шинжлэх ухаан, технологийн судалгаа хийх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, сургалт, инновацийн үйл ажиллагаа эрхлэх, төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага мөн.

1.2. Парк нь үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Шинжлэх ухаан, технологийн тухай”, “Инновацийн тухай” болон Монгол Улсын хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Парк бие даасан орон нутгийн өмчит хуулийн этгээд бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

ХОЁР. ПАРКИЙН УДИРДЛАГА

2.1. Паркийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, зардал, сургалт, судалгаа эрхлэгчидтэй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид энэ дүрэмд “ТУЗ” гэх) батална.

2.2. Паркийн сургалт, судалгааны үйл ажиллагааг чиглүүлэх паркийн дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн (цаашид энэ дүрэмд “Зөвлөл” гэх) бүрэлдэхүүн, ажиллах журам зэргийг ТУЗ батална.

2.2. Паркийн захирлыг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Засаг дарга паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэгтэй байна.

2.3. Засаг дарга дараах бүрэн эрхийг эдэлнэ:

а/ ТУЗ-ийн бүрэлдэхүүний томилох тухай санал боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

б/ Төрийн бодлого, хууль тогтоомж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

в/ Паркийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн тухай санал боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

г/ Паркийн өмчийн хэлбэрийг өөрчлөх, татан буулгах санал боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

д/ Паркийн эд хөрөнгийн тооллого явуулж, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах, шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулах;

2.4. Паркийн захирал нь дор дурдсан үйл ажиллагаа эрхэлнэ:

а/ Паркийн үндсэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

б/ Паркийг төлөөлж дотоод, гадаадын болон олон улсын байгууллагатай харилцах;

в/ Паркийн ажилтан нарыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулах, тэдний ажил үүргийн хуваарийг батлах, хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажилтнуудын албан тушаалын цалин, нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоон олгох, сургалт, судалгааны ажилтан гэрээгээр авч ажиллуулах, хууль, тогтоомжид заасан буцалтгүй тэтгэлэг, тусламж үзүүлэх;

г/ Паркийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд заасны дагуу сургалт, судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, хуулийн этгээд, иргэдтэй хуулийн хүрээнд гэрээ байгуулах;

д/ Паркийн үйл ажиллагааны талаар хууль тогтоомжийн хүрээнд тушаал гаргах, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсэг зурах;

ГУРАВ. ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

3.1. Парк дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/ Суурь судалгааны ажил болон орон нутгийн захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийг судлах, олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, зохицуулалт хийх, тайлан тэнцлийг гаргуулан авч дүн шинжилгээ хийх, илэрсэн зөрчил доголдлыг арилгах;

б/ Орон нутгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдэд сургалт явуулах, инновацийн үйл ажиллагаа эрхлэх;

в/ Шинжлэх ухаан, технологийн төслийн болон суурь судалгааны сэдэвт ажлын өртөг, зардлыг нарийвчлан хянаж батлуулах;

г/ Шинжлэх ухаан, технологи, инновацийн төслийн захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих, хэрэгжүүлж дууссан төслийн бүртгэл хөтлөх;


д/ Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлын үр дүнг хуулийн этгээдээр дамжуулан үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гэрээгээр хамтарч ажиллах;

е/ Гадаад орны шинжлэх ухааны парк, түүнтэй адилтгах байгууллагатай хамтарч ажиллах, хамтарсан суурь, хавсарга судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх;

ё/ Шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, эрдэм шинжилгээний хурал, төслийн уралдаан, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, семинар, үзэсгэлэн зохион байгуулах;

ж/ Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслийн хэрэгжилтийн явц, тэдгээрийг хэрэгжүүлэгч үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн этгээдийн үйл ажиллагааг ТУЗ-д тайлагнах, нийтэд мэдээллэх;

з/ Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс захиалсан төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх;



и/ Эрдэм шинжилгээний байгууллагын материаллаг бааз, судалгааны лабораторийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

к/ Паркийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний хурал, төслийн уралдаан, хэлэлцүүлэг, семинарын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн эдгээд хэрэгжүүлэх;

ДӨРӨВ. ПАРКИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ

4.1. Паркийн хөрөнгийг аймгийн Засаг даргын шийдвэрээр захиран зарцуулна.

4.2. Паркийн хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл, санхүүжилт нь Инновацийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эх үүсвэр болон дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

а/ Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг борлуулсан, сургалт, судалгаа гүйцэтгэсэн, үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээнд заасан хувь хэмжээгээр бүрдүүлсэн санхүүжилт;

б/ Орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтарсан төсөл хэрэгжүүлэх үед тэдгээртэй байгуулсан гэрээний үнийн дүн;

в/ Эрдэнэт сан болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрийн санхүүжилт;

4.3. Парк нь үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг дүгнэж, үр дүн, тайланг үндэслэн санхүүжилтийн тооцоог хийнэ.

4.4. Паркийн хөрөнгийн тухайн жилийн үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулна.

ТАВ. ПАРКИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ, ХЯНАХ

5.1. Паркийн захирал хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, ТУЗ-ийн өмнө жил бүрийн эхэнд тайлагнана.

5.2. Паркийн олсон орлого, зарлагын тайланг Татварын албанд хууль заасан хугацаанд тайлагнана.

5.3. Паркийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Монгол Улсын Үндэсний Аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргана.

5.4. Паркийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитийн дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлнэ.

5.5. Паркийн хөрөнгийн зарцуулалтад хуулийн холбогдох эрх бүхий хяналтын байгууллагууд хяналт тавина.

5.6. Паркийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалттай холбогдсон маргааныг ТУЗ шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл хуулийн байгууллагад зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Паркийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.